



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар Б/59

Хэрлэн сум

Л.Нямдоржийг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйл, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, 56 дугаар зүйлийн 56.1, 56.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл", Засгийн газрын 2022 оны "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан "Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", 4 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", аймгийн Засаг даргын 2022 оны "Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" Б/34 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Лхагвасүрэнгийн Нямдоржийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн жолоочоор 2022 оны 7 дугаар сарын 01-ээс томилсугай.

2.Л.Нямдоржийн сарын үндсэн цалинг ТҮ-3 зэрэглэлээр тогтоон, 569,585 (таван зуун жаран есөн мянга таван зуун наян тав) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5 хувиар, ур чадварын нэмэгдлийг 25 хувиар, ажил, албан тушаал хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 15 хувиар тооцож тус тус олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3.Хөдөлмөрийн гэрээ, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Л.Нямдоржид үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030385